

ХЯТАД УГИЙГ КИРИЛЛ ҮСГЭЭР ГАЛИГЛАХ АСУУДАЛД

*МУИС, ОУХС-ийн багш
Б.Гэрэлт-Ирээдүй*

Сүүлийн үед харь үг хэллэг хэрэглэх нь илт олширч, онохоосоо алдах нь их, мэдэхээсээ мэдэмхийрэх нь илүү болсон нь тун харамсалтай. Бичихэд бийр нугармаар, хэлэхэд хэл хугармаар буруу зөрүү үг хэллэг хэвлэл номын хуудаснаа олонтаа гарах болсон нь өөрийн эрхгүй халаглахад хүргэж байна.

Аливаа хэлээр ярилцагч ард түмний зан заншил, хэл соёлыг хүндэтгэн, тэдгээр орны төрийн зүтгэлтэн, алдартнуудын овог нэр болон нийслэл хот зэрэг том хотууд, бусад хүн, зарим газар орон, уул усны нэр хэвгийг яг өөрсдийнх нь хэлж дууддагаар кирилл бичгээрээ галиглан буулгаж бичиж тэмдэглэх, зөв дуудаж хэлж хэвших нь бидний хэл соёлын хэр хэмжээг илтгэх юм. Гэтэл манай хэвлэл мэдээллээр аливаа гадаад эх хэлийг нь мэдэхгүйн харгайгаар тухайн орны их хүмүүс, эрдэмт мэргэдийн нэр, газар орон, хүний нэрийг огт ондоогоор бичиж ярьсаар ирлээ.

Монголчууд бид өөрийн гэсэн хэлгүй мэт гадаад үгийг галиглан буулгахдаа орос хэлийг хуулбарлан хэрэглэж иржээ. Джейн, Джек, Джон, Джеймс, Джамбул, Гон-Конг, Гамбург, Гитлер, Гавана, голливуд, гамбургер, Сеул, Пхеньян, Самсунг, вонг, Чой, Франц, Парис, Сансино, Косю, Хонсю, Хиросима, Синдзюку, Сумо зэрэг олон үг утгаа Жейн, Жек, Жон, Жеймс, Жамбул, Хон-Кон, Хамбург, Хитлер, Хавана, холивуд, хамбургер, Сеул, Пён Ян, Сам Сон, вонь, Чүз, Франс, Патый, Санширо, Кюсю, Хоншю, Хирошима, Шинь Жүкү, Сүмоо гэж дууддагийг дээрх хэлүүдийг гадарлах хэн бүхэн мэднэ.

Англи монгол хэлний ж. 3 гийгүүлэгч авианууд аль аль нь адилхан хатуу дуудагддаг. Харин орос хэлнээ эл гийгүүлэгчүүдийг зөөлөн дуудлагатайгаас нь ялгахын тулд өмнө нь "д" нэмж бичин хатуу дуудлагыг нь тэмдэглэдэг билээ. Иймд монголоор дээрх гийгүүлэгчтэй үг бүрийг оросчлон өмнөх "д" гийгүүлэгчтэй нь хэрэглэх гэвэл бичихэд илүүц, уншихад хэл эвлэхгүй хэцүү бөгөөд зөв юмыг зориуд буруу болгосонтой ялгаа юун.

Урьд радио телевизийн мэдээнээс хятадын "Жэнь минь жибао" хэмээх сонинны нэр олонтаа сонсож (одоо ч ингэж хэлдэг), ном сонин, сурах бичгээс Хятадын их зохиолч Лу Синь, Го Мо Жо хэмээн бичиж тэмдэглэснийг уншиж байсан бол хятад хэл гадарлах болоод, энэ нь "Рэнь минь ри бао" сонин, Лу Сүнъ, Гуо Мо рүо хэмээх зохиолч болохыг мэдэж авч билээ. Энэ мэтээр Тай цзи цэюань, Тянь Цзинь, Хань Чжоу, Ши цзя Зон, Чжао Цзы Ян, Цзяо Ши, Зянь Зө Минь, Ли Пен, Ли Бо зэргээр зарим нэр томъёо, газар ус, хотын нэр болоод хүний нэр алдрыг радио телевизээр буруу хэлж дуудаж, хэвлэл номд олон янзаар буруу ташаа бичсээр л байх юм. Эдгээр үс нь утгаа Тай эи цүань, Тээнъ эин, Хан Жюу, Ши Зя Жуан, Жао Зы ян, Цяо Ши, Зэнь Зө минь, Ли Пен, Ли Бай гэж хэлж тэмдэглэвэл зөв болох юм.

Өдгөө Хятад улстай тал талын харилцаа өргөжиж, хятад хүний нэр, овог, газар усны нэр, байгууллага, нэгтгэл (компани)-ийн нэр хаяг зэргийг кирилл үсгээр галиглан бичих хэрэгцээ өдөр болгон гарч, тэр бүрийд хятад үгийг буруу сонсож буруу бичих, буруу унших нь нэн элбэг боллоо. Манайд хятад хэл сонирхон сурагчдын тоо нэмэгдсээр байгаа хэдий ч хятад үгийг кирилл үсгээр тэр бүр зөв галиглан буулгах тогтсон журам байхгүйгээс хүн бүр өөр өөрийнхөөрөө буруу зөрүү бичиж уншсаар байна. Иймд хятад үгийг монголчууд бид кирилл үсгээр хэрхэн галиглах талаар нэгдсэн нэг журмыг тогтоон хэрэглэж хэвших зайлшгүй шаардлагатай болоод байна. Бид өнөөг хүртэл оросын журмыг л тэр чигээр нь хэрэглэсээр ирсэн гэж болно. Гэтэл энэ нь зөвхөн орос хүний сонсгол болоод хэлний онцлогт л тохирсон галиг байдаг билээ.

Л.Жамсран доктор "Хятад, англи, орос, монгол бичгээр хятад үг галиглах харьцуулсан лавлах" (1996)-даа: "Хятад хэлний авиаг нэг мөр болгон тэмдэглэж чаддаг орос галигийн бүх үсэг нь монгол үсэгт хэрэглэгдэж буй кирилл бичигт байгаа учир манай уншигчид

түүний өргөн хэрэглэх бололцоотой" (5х) гэжээ. Хэдийгээр уг галигт хэрэглэгдэж байгаа бүх кирилл үсгийг бид хэрэглэдэг ч орос галигийг яг тэр чигээр нь хэрэглэвэл зарим нь монгол хүний хэлэхүйн онцлогт тохирохгүй учир хятад үгийн үндсэн дуудлагаас бүр хол зөрүүтэй болон дуудагддаг. Иймд орос галигийг шууд авч хэрэглэх нь яавч үндэслэл муутай гэдэг нь тодорхой. Дээрх харьцуулсан лавлахад хятад үгийг кириллээр буулгасан орос галигийг жагсаагаад, заримыг нь хэрхэн унших талаар нэлээд хэдэн тайлбар (6-7х) хийсэн нь тун сайшаалтай боловч, орос галигийг тэр чигээр нь авч, бас түүнийгээ кирилл үсгээр буулгаснаар нь бус огт дуудагдахгүй үсэг биччихээд, үүнийг дуудахгүй гэх, гийгүүлэгчийг давхарлан биччихээд, тийм тийм эгшгийн өмнө байвал тэгж ингэж дуудна хэмээн тайлбар хийх нь илүүц зүйл юм. Учир нь, нэгдүгээрт, тэрхүү олон тайлбарыг хүн бүр анхааран тогтоож, яг зааврын дагуу зөв хэлж дуудах, галиглан бичсэн үг бүрийн ард зөв унших тайлбарыг дагуулах боломжгүй бөгөөд галиглан тэмдэглэсэн үсэг бүрийг тэр чигээр нь дуудах тул хятад үг, нэр томъёог дөхүү хэлэх бус харин ч буруу зөрүү хэлэхийн үүдийг нээж буй хэрэг ээ. Хоёрдугаарт, галиг гэдэг бол тухайн үгийг хэрхэн дуудахыг л тэмдэглэсэн тэмдэглэгээ тул түүнд дахин галиг тэмдэглэж буй мэт давхар тайлбар байж таарахгүй. Галиг нь уг үгийг дуудах хамгийн оновчтой, хоёргүй нэг л хувилбар байх учиртай бизээ.

Монгол хүний хувьд хятад хэлний ямар ч авиаг, ямар ч үеийг, ямар ч үгийг тун зөв, үгүйдээ ойролцоо дуудах бололцоотой. Хятад хэлэнд байдаг ч эгшит авиа халх аялгуунд байдаггүй ч дөрвөд зэрэг аялгуунд байдаг тул монгол хүн төвөггүй дуудаж болох юм. Ер нь монгол хүний өгүүлэхүйн эрхтэн, хоолойн эгшилтэн, хэлэхүйн онцлог нь ямар ч хэлээр цэвэрхэн өгүүлэх боломж чадвар бүхий гэж эрдэмтэд нотолсон байдаг.

Хятад үгийг бид зөв дуудаж, тэмдэглэж болохоор байтал ингэж буруу галиглаж байгаад санаа ихэд зовж явах болсоор уджээ. Харин "Арга билиг" сонины 1991 оны 10, 11-р дугаарт Ш.Бадраабат гэдэг хүний "Гадаад үгийг галиглахад" хэмээх гарчгийн дор саналаа бичсэнийг үзээд тун оновчтой, зөв зүйтэй санал байна гэж бодсон. Харин цэе, цэя гэсэн орос галигийг же, жя гэж тэмдэглэхээр санал болгосныг зө, зя гэвэл хятад

дуудлагадаа илүү дөхөж очмоор санагдаж билээ.

Манай нөлөө бүхий зарим нэг хэвлэлд БНХАУ-ын Ерөнхий сайдын нэрийг Жу Жун Жи, Жо Рун Жи, Жу Рэн Жи, Жу Рон Жи хэмээн олон янзаар буруу бичжээ. Жу Жун Жи хэмээсэн нь тэр чигээрээ орос галиг юм. Орос хэлэнд Жун гэж хэлэхэд "ж" үсэг нь зөөлөн хэлэгдэх тул хятад дуудлагатайгаа ойр сонсогддог. Харин бид монголоор энэ "ж"-г хатуу хэлэх тул хятад дуудлагаасаа огт өөр болчихож байна. Энэ нэр нь утгаа Жу Рун зи хэмээн бичиж дуудвал хятад дуудлагадаа тун ойр зөв болох юм. Харин Жу Рон жи хэмээсэн нь хятад дуудлагад нь дөхүүлэхийг хичээсэн сайшаалтай боловч Рон хэмээн арай л зөрүү бичжээ. Энэ нь хятад галигаар гонг, long, long хэмээн тэмдэглэж рун, тун, лун гэж дуудлагийг мэдэхгүйгээс болжээ.

Харь хэлний тогтсон үг хэллэг, хот суурин, хүний нэр алдар, газар усны нэр, хаяг зэргийг заавал монголчилно гэвэл дэндүү муйхар явдал болох авч, түүнийг тухайн хэлэнд нь аль болох ойртуулан зөв бичиж дуудах нь ертөнцийн соёлын жишигт нийцэх, хэн хүний хэлний соёл хийгээд боловсролд хэрэгтэй нь мэдээж.

Хятад хэлэнд ханз үсгийн дуудлагын латин галиг байдаг бөгөөд тэр нь хятад хүний хэлж байгаа үг авиа бүрийг үнэн зөв тэмдэглэж чаддаг билээ. Хятад хэлэнд нийт 407 үе байдаг. Хятад хэлний бүх л үг хэллэг энэхүү 407 үеэс л бүтсэн байдаг. Иймд эдгээр үеийг л зөв дуудаж чадваас хятад үг бүрийг зөвхөн авиан талаас нь зөв хэлж чадна гэсэн үг юм.

Ингээд хятад хэлний "путунхуа" аялгууны авиан галигийг орос хэлэнд тохируулан кирилл үсгээр галигласан галиг, түүнээс монгол хэлэнд тохирохгүй заримыг нь хэрхэн тохируулан галиглабал зохистойг харьцуулан жагсаалаа.

№	Хятад галиг	Орос галиг	Санал болгож буй кирилл Тайлбар	Тайлбар
1	za	цаа	за	
2	zha	чаа	жа	
3	e	э	е	
4	me	мэ	ме	
5	de	дэ	дө	

6	te	тэ	тө	
7	ne	нэ	нө	
8	le	лэ	лө	
9	ze	цзэ	зө	
10	ce	цэ	цө	
11	se	сэ	сө	
12	zhe	чжэ	жө	
13	che	чэ	чө	
14	she	шэ	шө	
15	re	жэ	рө	
16	ge	гэ	гө	
17	ke	кэ	кө	
18	he	хэ	хө	"х"-г хэлний хойгуур дуудна
19	zi	цзы	зы	
20	chi	чи	чы	
21	shi	ши	шы	
	ri	жи	ри	
	er	эр	ар	"р"-г зөөлөн дуудна
22	ai	ай	ай	
23	zai	цай	зай	
24	zhai	чжай	жай	
25	ei	эй	эй	
26	zei	цзэй	зэй	
27	zhei	чжэй	жэй	
28	zao	цао	зао	
29	zhao	чжао	жао	
30	gao	жао	рао	
31	ou	оу	өү	
32	zou	цоу	зоу	
33	zhou	чжоу	жоу	
34	rou	жоу	рөү	
35	zan	цзань	зань	
36	zhan	чжань	жань	
37	gan	жань	рань	
38	zen	цзэнь	зэнь	

39	zhen	чжэнь	жэнь	
40	gen	жэнь	рэнь	
41	zang	цзан	зан	
42	zhang	чжан	жан	
43	gang	жан	ран	"р"-г зөөлөн дуудна
44	eng	эн	өн	
45	heng	бэн	бөн	
46	peng	пэн	пөн	
47	meng	мэн	мөн	
48	feng	фэн	фөн	
49	deng	дэн	дөн	
50	teng	тэн	төн	
51	neng	нэн	нөн	
52	leng	лэн	лөн	
53	zeng	цзэн	зөн	
54	ceng	цэн	цөн	
55	seng	сэн	сөн	
56	zheng	чжэн	жөн	
57	cheng	чэн	чөн	
58	sheng	шэн	шэн	
59	reng	жэн	рөн	
60	geng	гэн	гөн	
61	keng	кэн	көн	
62	heng	хэн	хөн	"х"-г хэлний хойгуур дуудна
63	zong	цзун	зун	
	zhong	чжун	жун	
64	gong	жун	рун	"р"-г зөөлөн дуудна
65	ji	цзи	зи	
66	jia	цзя	зя	
67	jiao	цзяо	зяо	
68	die	дэ	де	
69	jie	цзэ	зэ	
70	you	ю	ёу	
71	miu	мю	мюу	

72	diu	дю	дюу	
73	niu	ню	нюу	
74	liu	лю	люу	
75	jiu	цю	цюу	
76	qiu	цю	цюу	
77	xiu	сю	сюу	
78	yan	янь	еэнь	
79	bian	бянь	бээнь	
80	pian	пянь	пээнь	
81	mian	мянь	мээнь	
82	dian	дянь	дээнь	
83	tian	тянь	тээнь	
84	nian	нянь	нээнь	
85	lian	лянь	лээнь	
86	jian	цзянь	зээнь	
87	qian	цянь	цээнь	
88	xian	сянь	сээнь	
89	jīn	цзинь	зинь	
90	yang	ян	ан	
91	jiang	цзян	зян	
92	jīng	цзин	зин	
93	jīong	цюн	зюн	
94	wu	у	у	
95	bu	бу	бу	
96	pu	пу	пу	
97	mu	му	му	
98	fu	фу	фу	
99	du	ду	ду	
100	tu	ту	ту	
101	nu	ну	ну	
102	lu	лу	лу	
103	zu	цзу	зу	
104	cu	цу	цу	
105	su	су	су	
106	zhu	чжу	жү	
107	chu	чу	чү	
108	shu	шу	шү	

109	gu	гү	гү	
110	qu	кү	кү	
111	ku	кү	кү	
112	zhua	чжуа	жуа	
113	gua	гуа	гуа	
114	duo	до	дуо	
115	tu	то	туо	
116	pu	но	нуо	
117	lu	ло	луо	
118	zuo	цзо	зүо	
119	cuo	цо	цүо	
120	suo	со	сүо	
121	zhuo	чжо	жүо	
122	chuo	чо	чүо	
123	shuo	шо	шүо	
124	guo	го	гүо	
125	guo	го	гүо	
126	kuo	ко	күо	
127	huo	хо	хүо	
128	wai	вай	вай	
129	zhuai	чжуай	жуай	
130	zui	цзуй	зүй	
131	zhui	чжуй	жүй	
132	gui	жүй	гүй	"p"-г зөөлөн дуудна
133	zuan	цзуань	зуань	
134	zhuan	чжуань	жуань	
135	guan	гуань	гуань	
136	dun	дунь	дунь	
137	zun	цзунь	зунь	
138	sun	цунь	цунь	
139	sun	сунь	сунь	
140	zhun	чжунь	жунь	
141	chun	чунь	чунь	
142	shun	шунь	шунь	
143	gun	гунь	гунь	"p"-г зөөлөн дуудна